



**УЛААНБААТАР ХИВС**  
хувьцаат  компани

**“УЛААНБААТАР ХИВС” ХУВЬЦААТ  
КОМПАНИЙН 2023 ОНЫ ХУВЬЦАА  
ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН  
МАТЕРИАЛ**

Улаанбаатар хот.

2023.03.28

## **Эрхэм хүндэт хувьцаа эзэмшигчид ээ !**

Монгол улсын Компанийн тухай хууль болон компанийн дүрмийн дагуу “Улаанбаатар хивс” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2023 оны 03-р сарын 31-ны өдрийн 11.00 цагт компанийн хурлын танхимд хийнэ.

Хувьцаа эзэмшигчдийн хуралдаа хүрэлцэн ирэхийг урьж байна.

### **Хурал зохион байгуулах комисс**

Комиссын дарга: Утас: 88023515, e-mail: [battsetsegnambar@gmail.com](mailto:battsetsegnambar@gmail.com)

Гишүүд : Утас:70142556, 99880912

Факс :11-343311,

e-mail : [ubcarpet@gmail.com](mailto:ubcarpet@gmail.com)

Web site : [www.mongolia-carpet.mn](http://www.mongolia-carpet.mn)

**“Улаанбаатар хивс” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн  
2023 оны ээлжит хурлын хэлэлцэх асуудал**

- 1. “Улаанбаатар хивс” ХК-ийн 2022 оны үйл ажиллагааны үр дүн, 2023 оны үндсэн зорилт, үзүүлэлтийн тухай**
- 2. “Улаанбаатар хивс” ХК-ийн 2022 оны санхүүгийн тайланд аудитын байгууллагаас өгсөн дүгнэлт**
- 3. Компанийн ТУЗ-ийн үйл ажиллагааны 2023 оны зардлын төсөв батлах тухай**

## Хурлын дэг

1. Хурлын ирцийг бүртгэж, мэдээлэх  
20 минут /10.40-11.00/
2. Хурал нээж, хурлын тэргүүлэгчид, нарийн бичгийн дарга нарыг сонгох  
5 минут
3. Хурлын хэлэлцэх асуудал, хурлын дэг тогтоох  
Хурлын тэргүүлэгчид  
10 минут
4. “Улаанбаатар хивс” ХК-ийн 2022 оны үйл ажиллагааны үр дүн,  
2023 оны үндсэн зорилт, үзүүлэлтийн тухай  
Илтгэгч ТУЗ-ийн дарга Ц.Зоригт  
20 минут
5. “Улаанбаатар хивс” ХК-ийн санхүүгийн тайлан аудитын  
байгууллагаас өгсөн дүгнэлт  
Илтгэгч: ТУЗ-ийн дэргэдэх аудитын хорооны  
гишүүн/ 10 минут
6. Компанийн ТУЗ-ийн үйл ажиллагааны 2023 оны зардлын төсөв  
батлах тухай  
Илтгэгч: ТУЗ-ийн н. б. дарга Н.Батцэцэг  
10 минут
7. Хэлэлцсэн асуудлын талаархи санал, шүүмжлэл  
Хурлын тэргүүлэгчид  
Хүн тус бүрд 5 минут/
8. Хэлэлцсэн асуудлаар санал хураалт явуулж, дүнг танилцуулах  
Тооллогын комисс  
30 минут
9. Хурлын шийдвэрийн төслийг батлуулж, хурал хаах  
Хурлын тэргүүлэгчид  
10 минут

Хурлыг 03-р сарын 31-ний өдөр 11.00 – 14.00 цагт багтаахаар төлөвлөсөн.



## **“УЛААНБААТАР ХИВС” ХК-ИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА**

Монгол улсын машины аргаар хивс нэхэх анхны үйлдвэр болох “Улаанбаатар хивс” ХК нь 1971 онд БНАГУ-ын /хуучин нэрээр/ техник эдийн засгийн тусламжтайгаар баригдаж, жилд 2 ээлжээр 350.0 мянган м<sup>2</sup> хивс үйлдвэрлэх хүчин чадалтай ашиглалтанд орсон бөгөөд 1978 онд бүрэн хүчин чадлынхаа хэмжээнд хүрч ажилласан. Үүнээс хойш 1979-1980 онуудад нэхэх цехийг, 1989-1990 онд ээрэх цехийг тус тус өргөтгөсөн.

Тус компани нь 1992 онд 100 хувь хувьчлагдаж, хувьцаат компани болсон ба одоо 895 хувьцаа эзэмшигчидтэй.

Компани нь одоогийн байдлаар 110 гаруй ажилчидтай, хонины ноосыг угааж, угаасан ноосоор ээрмэл утас бэлтгэн төрөл бүрийн өнгө, дизайнтай Алтанбулаг, Алтан-Өргөө, Саян, Богд, Улаанбаатар, Алтан-Өргөө, Отгонтэнгэр нэртэй цэвэр ноосон хивс үйлдвэрлэж дотоод, гадаадын хэрэглэгчдийн хэрэгцээнд нийлүүлдэг. Үүнээс гадна захиалгат хивс, эсгий гудас, машины суудлын бүрээс, улавч, тааран цүнх, килим /ноосон бүтээлэг/, сүлжмэл бүтээгдэхүүн зэрэг бусад туслах үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнүүд үйлдвэрлэж байна.

## **“Улаанбаатар хивс” ХК-ийн эрхэм зорилго**

Хувьцаа эзэмшигчдийн эрх ашиг, сонирхлыг эрхэмлэн дээдэлж, хивсний үйлдвэрлэлийн үр ашгийг дээшлүүлж, хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээ, шаардлагад нийцсэн чанартай сайн бүтээгдэхүүн үйлдвэрлэн худалдаж, улмаар улс нийгмийн хөгжилд тодорхой хувь нэмэр оруулах нь компанийн эрхэм зорилго юм.

“Улаанбаатар хивс” ХК нь 2022 онд хувьцаа эзэмшигчдийн хурлаас дэвшүүлсэн зорилт, шийдвэрүүдийг хэрэгжүүлж, ТУЗ-өөс техник, технологийн шинэчлэл хийх, бүтээгдэхүүний өртөг зардлыг бууруулах, эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх, гадаад дотоодын хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээнд нийцсэн олон нэр төрлийн, чанартай бүтээгдэхүүн үйлдвэрлэн зах зээлээ тэлэх зэрэг үндсэн зорилтуудыг хэрэгжүүлж, компанийн нийт ажилтнууд, хамт олны хүч хөдөлмөрийг зүй зохистой зохион байгуулж ажиллаж ирлээ.

Манай компани нь 2023.03.09-ны бүртгэлийн өдрөөр:

- Үнэт цаасны 50 БДК-ийн 892 хувьцаа эзэмшигчтэй
- Компанийн зах зээлийн үнэлгээ 15,2 тэрбум төгрөг байна.
- Өнгөрсөн 52 долоо хоногийн дундаж үнээр нэгж хувьцааны үнэ 28,000-47,600 төгрөгийн хооронд хэлбэлзэж,
- Нийт хувьцааны 95,4 хувь нь 8 хувьцаа эзэмшигчид төвлөрдөг ба 16 гадаадын иргэд, компаниуд цөөн тооны хувьцааг эзэмшдэг.
- Бид 2021 оны ажлын үр дүнгээр нэгж хувьцаанд 1200 төгрөг буюу нийтдээ 485,8 сая төгрөгийн ногдол ашгийг Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвөөр дамжуулан нийт хувьцаа эзэмшигчдийн дансанд шууд олгосон болно.
- Тайлант 2022 оны ажлын үр дүнгээр нэгж хувьцаанд 1570 төгрөг буюу 635,6 сая төгрөгийн ногдол ашиг хуваарилахаар компанийн ТУЗ-өөс шийдвэрлэсэн болно.
- Бид компанийн тухай, үнэт цаасны тухай хууль, журмыг мөрдөж, МХБ болон үнэт цаасны төлбөр тооцооны байгууллагуудтай зохих ёсоор хамтран ажиллаж, холбогдох гэрээ, мэдээ, тайлан, төлбөр тооцоог зохих журмын дагуу хэрэгжүүлж ирсэн.

“Улаанбаатар хивс” ХК-ийн 2022 оны хувьцааны хөдөлгөөнийг харуулбал,



2022 онд компанийн ТУЗ 3 удаа танхимаар хуралдаж, асуудал шийдүүлж ажиллалаа.

СЗХорооны тогтоолын дагуу “Компанийн кодекс”-ыг хэрэгжүүлэх хүрээнд холбогдох журмуудыг шинэчлэн боловсруулж, компанийн website-д байршуулсан.

ТУЗ-ийн даргын хувьд, үйлдвэрлэлийн үйл ажиллагаа, бүтэц, зохион байгуулалт, техник, технологийн шинэчлэлийн ажилд биечлэн оролцож, гүйцэтгэх удирдлагатай хамтдаа идэвхитэй ажиллаж, цаг үеийн тулгамдсан асуудлуудыг газар дээр нь хэлэлцэн шийдвэрлэж ажилласан байна. Тухайлбал, бэлэн бүтээгдэхүүний цахим борлуулалт, мэдээлэл сурталчилгааг нэмэгдүүлэх, материал, түүхий эд, ноос бэлтгэл, санхүүжилт, ажлын байрны дотоод тохижилт, эрүүл ахуй нөхцөлийг сайжруулах, техник, технологи, сантехникийн шугам сүлжээг засварлах зэрэгт ихээхэн анхаарал тавьж ажилласан.



## **“Улаанбаатар хивс” ХК-ийн 2022 оны үйл ажиллагааны тайлан**

Тайлант 2022 онд “Улаанбаатар хивс” ХК-ийн хамт олон дараахь үндсэн үзүүлэлтүүдийг хангаж ажиллалаа.

- 50338 м2 хивс үйлдвэрлэж, 49616 м2 хивс борлуулсан нь үнийн дүнгээр 5,404,974 сая төгрөгт хүрч, урьд оноос 725, 506 сая төгрөгөөр буюу 16%-аар өсөв.
- 838,015 сая төгрөгийн цэвэр ашигтай ажилласан нь өмнөх оныхоос 105,333 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Дээрх үр дүнд хүрэхэд компанийн нэгж, албад дараахь ажлуудыг гүйцэтгэлээ.

### 1. Үйлдвэрлэлийн алба

- 2022 онд 245,7 тн ноос бэлтгэлээ.
- Ноос ялгалтын гарц 74,0%, угаалтын гарц 56,6% байлаа.
  
- Ээрэх цехэд:
  - 12/3 номерын утас 21812 кг
  - 15/3 номерын утас 58993 кг, нийт 80805 кг утас ээрч, ээрмэлийн гарц байв.
  - Хялгас ялгах цехэд 3140 кг ноос ялгаж, гарц нь 20 % байлаа.
  
- Будах цехэд:
  - 80689 кг утас будаж төлөвлөгөө 93,14%-тай биелэв.
  - Будах III аппаратыг автоматжуулах, будалтын горимыг хянах самбарт тохируулах, уур усыг автоматаар хаадаг болгох зэрэг ажлууд хийснээр хэмнэлт гарахаас гадна будалтын чанарт сайнаар нөлөөлөх болсон.

- Нэхэх цехэд нэхсэн хивсний нэр төрлийг үзүүлбэл:
  - Алтанбулаг 34732,51 м2
  - Саян 13923,75 м2
  - Алтан-Өргөө 497,00 м2
  - Улаанбаатар 652,00 м2
  - Богд 1107,55 м2
  - Алтан-Өргөө 498,00 м2
  - Отгонтэнгэр 96,00 м2 буюу нийт 51009,58 м2 хивс нэхэв.
  
- Нөхөн засах гүйцэтгэх цехэд 50338 м2 хивс гүйцэтгэн боловсруулж, төлөвлөгөө 98,7 % биелэв.
  
- Оёдлын тасагт, гудас, сандлын хивс, тааран уут, хивсэн углааш, ажлын хувцас зэргийг үйлдвэрлэн борлуулалтанд тушаалаа.

## 2. Маркетингийн алба

- Тайлант онд 49616 м2 хивс борлуулсан нь өмнөх оныхоос, үнийн дүнгээр 16,0% өссөн.
- Нэрийн барааны дэлгүүрүүдээр борлуулалт хийснээс гадна 94 захиалагчийн 3137 м2 хивсийг 390 066 600 төгрөгөөр гүйцэтгэв.
- Экспортод 1086 м2 хивс гаргаж, 115,3 сая төгрөгийн борлуулалт хийсэн.
- “Улаанбаатар хивс” ХК –facebook-ийг ажиллуулж, хэрэглэгчдээс 56960 like авсан нь өмнөх оныхоос 18 % өссөн байна. 940 226 хандалт авсан байна.
- Монголын зах зээлд 2022 онд “Натурал текстайл” групп 341 710 м2 хивс, манай компани 50300 м2 үйлдвэрлэсэн нь ойролцоогоор 12,0%-ийг эзэлж байна.
- Нэрийн барааны дэлгүүрт хэрэглэгчдэд зориулсан ариун цэврийн өрөө, тухлах орчин зэрэг хэсэгчилсэн тохижилт хийсэн.

### 3. Сургалт-хүний нөөцийн алба

- Оны эхэнд 114 ажилтантай байсан бол, ажилд шинээр 20 хүн орж, 14 хүн үлдэж, бусад 13 хүн халагдсанаар оны эцэст 115 ажилтанай болоод байна.
- Ажиллагсдын дундаж нас 4 ба компанид ажилласан дундаж жил 14 байна.
- Нийт ажиллагсдын 35% нь тэтгэврийн насных байна.
- Одоогоор 16 ажлын байранд сул орон тоо байгаа бөгөөд яаралтай сургах шаардлагатай мэргэжил байна.
- Ажиллагсдын хувцас солих өрөөг иж бүрэн тохижууллаа.

### 4. Санхүү-эдийн засгийн алба

- Санхүүгийн болон татварын тайлангуудыг цаг хугацаанд нь гаргаж, холбогдох газруудад өгсөн.
- Мөнгөний үлдэгдэл болон хэрэгцээг тухай бүрд тооцон, удирдлагын шийдвэрээр зарцуулж, зээл, татваруудыг бүрэн барагдуулсан.
- Түрээслэгчидтэй тооцоог нэхэмжлэн гаргаж тооцоог барагдуулав.
- Баянхонгорт авсан 149400 кг, Улаанбаатарт авсан 96350 кг ноосны 392,1 сая төгрөгийг барагдуулж, ноосны урамшууллын тооцоог 896 малчин тус бүрээр Е-баримтаар тулган, ННХ болон татварын байгууллагад мэдээлсэн.
- Шаардлагатай дамжлагуудад ажлын зураг авалт хийсэн.
- Турк улсаас 4,0 сая төгрөгийн гэр ахуйн байраа онлайнар захиалж, авчран борлуулж, 4,5 сая төгрөгийн ашиг олсон. Одоогоор 6,1 сая төгрөгийн бараа нэмж захиалаад байна.
- “Транскапитал” ББСБ-тай гэрээ байгуулснаар, 22,0 сая төгрөгийн борлуулалт хийгдсэн.
- Хивсний борлуулалтын үнэд өөрчлөлт оруулах тооцоог хийж, 2022-01-13-наас хивсний үнийг 10-20 % нэмэгдүүлсэн.
- Үндсэн хөрөнгөнд 627,6 сая төгрөгийн орлого авч бүртгэлд тусгасан.

## 5. Бусад ажлууд:

- Компанийн барилгын дээврийн 11090 м<sup>2</sup> талбайд мембран наалт нааж 562,3 сая төгрөг зарцуулааа.
- Ноосны складын дээвэр 1380 м<sup>2</sup> талбайг хар цааслав.
- 120 уртааш метр ус зайлуулах шугам хоолой шинэчлэв.
- Ээрэх цехийн цонхнуудыг томсгож, шинэчилсэн.
- Нисэх дэх аж ахуйн хашааг шинэчилсэн.
- Эсгийн цехийг засварлаж, нэмж тоноглов.

## 2023 оны үйл ажиллагааны үндсэн зорилт

2023 онд үйл ажиллагааны үндсэн үзүүлэлтүүдийн төлөвлөгөөг дараахь байдлаар тогтоож байна.

- Үйлдвэрлэл 52000 м2
- Борлуулалт 6 200 000,0 мян. төгрөг
- Хөрөнгө оруулалт 600,0 сая төгрөг
- Цэвэр ашиг 900,0 сая төгрөг
- Үйлдвэрлэлийн нэгж өртөг 95000 төгрөг

2023 онд маркетингийн алба дараахь зорилтыг тавьж байна.

- Өөрийн компанийн бараа бүтээгдэхүүнээс гадна адил төстэй буюу гэр ахуйн зориулалттай дотоод, гадаадын бүтээгдэхүүнийг оруулж, нэрийн барааны дэлгүүрээрээ борлуулах
- Борлуулалтын шинэ цэг судалж, нээх
- Сурталчилгаанд сошиал сувгуудыг илүү ашиглах
- Шинэ нэр төрлийн хивс, килим үйлдвэрлэл, борлуулалтыг шинэ хэлбэрээр зохион байгуулах

Манай компанийн хамт олон 2023 онд үйлдвэрлэл технологийн шинэчлэл, хөрөнгө оруулалтын үр өгөөжийг нэмэгдүүлэх, бүтээгдэхүүний нэр төрөл, чанар, сав баглаа боодлыг сайжруулж, гадаад дотоод харилцаа, борлуулалтын сүлжээг нэмэгдүүлэхэд анхаарал тавьж тавьсан зорилтуудаа хэрэгжүүлэн ажиллах болно.

Бид монгол хонины цэвэр ноосон утсаар нэхсэн хивс дэлхийн өнцөг булан бүрд хүрч, хивсний илч дулаан, таатай мэдрэмжийг хэрэглэгчдэд бий болгохын төлөө ажиллана.

**Сайн үйлс дэлгэрэх болтугай.**

“Улаанбаатар Хивс” ХК-ийн 2022 оны санхүүгийн тайланд “АЯА ТАКС АУДИТ” ХХК – аас шалгалт хийж дуусаагүй байгаа тул 2023 оны 03-р сарын 27-нд урьдчилан ирүүлсэн дүгнэлтийг танилцуулж байна.



## ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

### АЯА ТАКС АУДИТ ХХК

Улаанбаатар хот, СБД, I хороо, V хороолол,  
14251, Чингисийн өргөн чөлөө 19-Б Бизнес  
таур 11 давхар Утас: 99994447, 98658500

№ \_\_\_\_\_  
Танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

### Улаанбаатар хивс ХК-ий Хувьцаа эзэмшигчид танаа

Бид Улаанбаатар хивс ХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх санхүүгийн байдлын тайлан, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн чухал бодлогууд, бусад тайлбар тодруулгуудад аудит хийлээ.

### Санхүүгийн тайланд удирдлагын хүлээх хариуцлага

Компанийн удирдлага нь Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-ын дагуу эдгээр санхүүгийн тайланг бэлтгэж, үнэн зөв толилуулах хариуцлагыг болон залилан эсвэл алдаанаас шалтгаалан материаллаг хэмжээний буруу илэрхийлэлгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх боломжийг хангахад шаардлагатай гэж удирдлагын тодорхойлсон дотоод хяналтын үүрэг хариуцлагыг хүлээнэ.

### Аудиторын хүлээх хариуцлага

Бидний хүлээх хариуцлага нь хийж гүйцэтгэсэн аудитдаа үндэслэн санхүүгийн тайлангуудад дүгнэлт өгөх явдал юм. Бид аудитаа Аудитын олон улсын стандартын дагуу хийж гүйцэтгэсэн. Эдгээр стандартууд нь санхүүгийн тайлангууд нь материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар зохистой нотолгоо олж авахын тулд аудитаа төлөвлөж гүйцэтгэх, ёс зүйн шаардлагуудыг мөрдөж ажиллахыг шаарддаг.

Аудитын ажилд санхүүгийн тайлангийн дүн болон тодруулгуудын талаар аудитын нотолгоо олж авах горимуудыг гүйцэтгэх ажил багтана. Аудитын горимуудын сонголт нь санхүүгийн тайлангууд нь аливаа заль мэх, алдаанаас шалтгаалан материаллагаар буруу илэрхийлэгдэх эрсдэлүүдийн үнэлгээг багтаасан аудиторын шийдлээс хамаарна.

Тэдгээр эрсдэлийн үнэлгээг хийхдээ аудитор санхүүгийн тайлангуудыг үнэн зөв бэлтгэн толилуулахтай холбоотой байгууллагын дотоод хяналтын системийг харгалзан үзэх бөгөөд энэ нь байгууллагын дотоод хяналтын үр дүнтэй байгаа эсэх талаар дүгнэлт өгөх зорилгоор биш, харин нөхцөл байдалдаа тохирсон аудитын горимуудыг тодорхойлоход чиглэнэ.

Аудит нь мөн байгууллагын удирдлагын сонгон хэрэглэж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын зохистой байдал, нягтлан бодох бүртгэлийн тооцооллуудын бодитой байдал, санхүүгийн тайлангуудын ерөнхий толилуулгыг үнэлэх ажлуудыг багтаана.

Бидний олж авсан аудитын нотолгоо нь бидний гаргасан аудитын хязгаарлалттай дүгнэлтийн суурь болоход хангалттай бөгөөд зохистой гэдэгт итгэж байна.

### **Хязгаарлалтгүй дүгнэлт**

Бидний үзэж байгаагаар хязгаарлалттай дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол Улаанбаатар хивс ХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 31- ний өдрийн байдлаарх санхүүгийн тайлангуудад санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг СТОУС-ын дагуу үнэн зөв толилуулсан байна.

**АЯА ТАКС АУДИТ ХХК  
УЛААНБААТАР ХОТ  
МОНГОЛ УЛС**

**2023 ОНЫ ..... ДУГААР  
САРЫН .....-НЫ ӨДӨР**

**Аудит хийсэн Улаанбаатар хивс ХК -ийн 2022 оны жилийн эцсийн тайлан тэнцэл**

I. БАЛАНС	2021-12-31	2022-12-31	Аудитлагдсан
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	1,376,093,201	1,916,939,018	1,916,939,018
Дансны авлага	30,068,641	145,411,277	145,411,277
Татвар, НДШ-ийн авлага	36,195,922	46,405,453	46,405,453
Бусад авлага	8,425,277	37,660,542	37,660,542
Бараа материал	1,491,269,942	1,276,005,727	1,276,005,727
Урьдчилж төлсөн зардал тооцоо	1,235,061,043	1,227,600,095	1,227,600,095
Үндсэн хөрөнгө	10,210,507,923	10,411,035,750	10,411,035,750
Бусад эргэлтийн бүс хөрөнгө	1,920,000	1,920,000	1,920,000
<b>НИЙТ ХӨРӨНГӨ</b>	<b>14,389,541,948</b>	<b>15,062,977,862</b>	<b>15,062,977,862</b>
Дансны өглөг	171,007,747	283,850,543	283,850,543
Банкны богино хугацаат зээл	1,567,589,403	1,896,691,990	1,896,691,990
Ногдол ашгийн өглөг	2,119,800	2,119,800	2,119,800
УОО	11,845,686	3,843,400	3,843,400
Үүнээс: төсөвт төлөх	-	-	-
Урт хугацаат зээл	112,727,273	-	-
Хувьцаат өр төлбөр	40,482,900	40,482,900	40,482,900
Нийт өр төлбөрийн дүн	1,905,772,809	2,226,988,633	2,226,988,633
Өмч	-	-	-
Эздийн өмчийн бусад хэсэг	11,834,725,134	11,834,725,134	11,834,725,134
Хуримтлагдсан ашиг (алдагдал)	649,044,005	1,001,264,096	1,001,264,096
Өмчийн нийт дүн	12,483,769,139	12,835,989,230	12,835,989,230
<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>14,389,541,948</b>	<b>15,062,977,862</b>	<b>15,062,977,862</b>



**ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН**

Үзүүлэлт	2021-12-31	2022-12-31	Аудитлагдсан
Борлуулалтын орлого ( цэвэр )	4,679,468,187	5,404,974,120	5,404,974,120
Борлуулалтын өртөг	3,719,702,790	4,091,724,711	4,091,724,711
Нийт ашиг ( алдагдал )	959,765,397	1,313,249,409	1,313,249,409
Түрээсийн орлого	565,784,398	690,326,991	690,326,991
Хүүгийн орлого	15,624,635	34,139,700	34,139,700
Бусад орлого	212,923,496	652,601,284	652,601,284
Борлуулалт, маркетингийн зардал	433,904,478	485,982,721	485,982,721
Ерөнхий ба удирдлагын зардал	181,808,983	250,904,295	250,904,295
Бусад зардал	324,692,016	696,252,327	696,252,327
Гадаад валютын ханшийн зөрүүний олз ( гарз )	1,572,630	(277,086,601)	(277,086,601)
Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз ( гарз )	(884,000)	-	-
Татвар төлөхийн өмнөх ашиг ( алдагдал )	814,381,080	980,091,439	980,091,439
Орлогын татварын зардал	81,698,815	142,076,549	142,076,549
Татварын дараах ашиг ( алдагдал )	732,682,265	838,014,890	838,014,890
Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал )	732,682,265	838,014,890	838,014,890
Орлогын нийт дүн	732,682,265	838,014,890	838,014,890
Нэгж хувьцаанд ноогдох суурь ашиг ( алдагдал )	1,810	2,070	2,070

**ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН**

Үзүүлэлт	Өмч	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	40,482,900.00	159,259,140.37	6,941,546,726.93
НББ-ийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-
Залруулсан үлдэгдэл	40,482,900.00	159,259,140.37	6,941,546,726.93
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	732,682,265.03	732,682,265.03
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-
Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-
Зарласан ногдол ашиг	-	(242,897,400.00)	(242,897,400.00)
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	5,092,920,447.42
2022 оны 1-р сарын 1-ний үлдэгдэл	40,482,900.00	649,044,005.40	12,524,252,039.38
НББ-ийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-
Залруулсан үлдэгдэл	40,482,900.00	649,044,005.40	12,524,252,039.38
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	838,014,890.34	838,014,890.34
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-
Өмчид гаргасан өөрчлөлт	-	-	-
Зарласан ногдол ашиг	-	(485,794,800.00)	(485,794,800.00)
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-
2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	40,482,900.00	1,001,264,095.74	12,876,472,129.72

**МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

Үзүүлэлт	12/31/2021	12/31/2022	Аудитлагдсан
<b>1. Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>
1.1 <u>Мөнгөн орлогын дүн (+)</u>	5,738,820,820.22	7,260,337,323.18	7,260,337,323.18
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсэний орлого	5,568,430,671.63	6,656,425,507.38	6,656,425,507.38
Бусад мөнгөн орлого	170,390,148.59	603,911,815.80	603,911,815.80
1.2 <u>Мөнгөн зарлагын дүн (-)</u>	4,523,762,680.07	6,231,750,139.35	6,231,750,139.35
Ажилагсад төлсөн	932,480,089.18	1,187,473,990.91	1,187,473,990.91
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	240,500,000.00	353,580,971.62	353,580,971.62
Бараа материал худалдан авахад төлсөн	2,135,215,951.78	2,527,499,254.09	2,527,499,254.09
Ашиглалтын зардалд төлсөн	25,015,287.48	543,081,912.59	543,081,912.59
Түлш, шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	5,397,829.00	6,039,951.26	6,039,951.26
Хүүний төлбөрт төлсөн	15,580,773.03	3,100,154.40	3,100,154.40
Татварын байгууллагад төлсөн	678,048,000.88	838,737,878.24	838,737,878.24
Бусад мөнгөн зарлага	491,524,748.72	772,236,026.24	772,236,026.24
<b>1.3 Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>1,215,058,140.15</b>	<b>1,028,587,183.83</b>	<b>1,028,587,183.83</b>
<b>2. Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>
2.1 <u>Мөнгөн орлогын дүн (+)</u>	15,624,635.27	34,139,700.25	34,139,700.25
Хүлээн авсан хүүний орлого	15,624,635.27	34,139,700.25	34,139,700.25
2.2 <u>Мөнгөн зарлагын дүн (-)</u>	-	-	-
<b>2.3 Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>15,624,635.27</b>	<b>34,139,700.25</b>	<b>34,139,700.25</b>
<b>3. Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>
3.1 <u>Мөнгөн орлогын дүн (+)</u>	1,502,042.67	52,015,985.52	52,015,985.52
Валютын ханшийн тэгшитгэлийн ашиг	1,502,042.67	52,015,985.52	52,015,985.52
3.2 <u>Мөнгөн зарлагын дүн (-)</u>	459,787,601.19	573,897,052.88	573,897,052.88
Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн	229,022,727.24	112,727,272.88	112,727,272.88
Төлсөн ногдол ашиг	230,752,530.00	461,169,780.00	461,169,780.00
Валютын ханшийн тэгшитгэлийн алдагдал	12,343.95	-	-
<b>3.3 Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(458,285,558.52)</b>	<b>(521,881,067.36)</b>	<b>(521,881,067.36)</b>
<b>4. Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>772,397,216.90</b>	<b>540,845,816.72</b>	<b>540,845,816.72</b>
<b>5. Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>603,695,984.14</b>	<b>1,376,093,201.04</b>	<b>1,376,093,201.04</b>
<b>6. Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>1,376,093,201.04</b>	<b>1,916,939,017.76</b>	<b>1,916,939,017.76</b>

**УЛААНБААТАР ХИВС ХК-ИЙН  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН  
ТОГТООЛ**

Дугаар 01/2023

2022-03-31

Улаанбаатар хот

Компанийн 2022 оны үйл ажиллагааны үр дүн,  
2023 оны үндсэн зорилтын тухай

“Улаанбаатар хивс” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар тус компанийн 2022 оны үйл ажиллагааны тайлан болон 2023 оны үндсэн зорилт, үзүүлэлтүүдийн талаар хэлэлцсэн, хувьцаа эзэмшигчдийн санал, шүүмжлэл болон тооллогын комиссын санал хураалтын үр дүнг үндэслэн ТОГТООХ нь:

1. “Улаанбаатар хивс” ХК-ийн 2022 оны үйл ажиллагааны үр дүнг тайлангаар хүлээн зөвшөөрсүгэй.
2. “Улаанбаатар хивс” ХК-ийн 2023 оны үйл ажиллагааны үндсэн үзүүлэлтүүдийг дараахь байдлаар тогтоон баталсугай.

- Үйлдвэрлэл	52 000,0 м2
- Борлуулалт	6 200,0 сая төгрөг
- Хөрөнгө оруулалт	600,0 сая төгрөг
- Цэвэр ашиг	900,0 сая төгрөг
- Үйлдвэрлэлийн нэгж өртөг	95 000 төгрөг

3. Компанийн үйлдвэрлэл, үйл ажиллагааны чиглэлээр тавьж буй үндсэн зорилтуудыг ханган биелүүлэхийн тулд 2023 онд компанийн техник, технологи, эдийн засгийн нөөц бололцоог илүү үр ашигтайгаар удирдан зохион байгуулж ажиллахыг компанийн төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлага, нийт ажилтнуудад үүрэг болгосугай.

ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ДАРГА

Ё.ЭНХТӨР

**УЛААНБААТАР ХИВС ХК-ИЙН  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН  
ТОГТООЛ**

Дугаар 02/2023

2022-03-31

Улаанбаатар хот

Компанийн ТУЗ-ийн 2023 оны  
үйл ажиллагааны зардлын төсөв  
батлах тухай

“Улаанбаатар хивс” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар компанийн ТУЗ болон хороодын 2022 оны зардлыг хэлэлцсэн хувьцаа эзэмшигчдийн санал, шүүмжлэл болон тооллогын комиссын санал хураалтын үр дүнг үндэслэн ТОГТООХ нь:

1. “Улаанбаатар хивс” ХК-ийн ТУЗ болон хороодын 2022 оны үйл ажиллагааны зардлын төсвийг 72.4 сая төгрөгөөр, хавсралт 01/2023-ын дагуу баталсугай.

ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ДАРГА

Ё.ЭНХТӨР

“Улаанбаатар хивс” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн  
2023 оны 03-р сарын 31-ний өдрийн хурлын  
Тэргүүлэгчдийн 02/2023 тоот тогтоолын  
Хавсралт №01

ТУЗ-ийн 2023 оны үйл ажиллагааны зардлын төсөв

№	Зардлын товч утга	Нийт дүн [₮]
1	Цалин: - ТУЗ-ийн дарга 1 х 12 сар х 650.0 мян. ₮ - Гишүүд: 8 х 12 сар х 450.0 мян. ₮ - ТУЗ-ийн нбд х 12 сар х 550.0 мян. ₮ <u>Хурлын ирцийн нэмэгдэл:</u> - 9 гишүүн х 12 сар х 100.0 мян. ₮	₮ 68,400,000.00
2	Бичиг хэрэгслийн зардал	₮ 500,000.00
3	Хэвлэл, телефон холбооны зардал	₮ 2,000,000.00
4	Бусад, сургалт, аттестатчилал	₮ 1,500,000.00
	<b>Дүн</b>	<b>₮ 72,400,000.00</b>